

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУДАЛДААНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс гадаад худалдааг зохицуулах арга хэмжээг тодорхойлж эдийн засгийн өсөлтийг дэмжих, үндэсний аюулгүй байдлыг хангахад оршино.

2 дугаар зүйл.Худалдааны хууль тогтоомж

2.1.Худалдааны хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь төрөөс гадаад худалдааг зохицуулах, хамгаалах, хөнгөвчлөх, дэмжихтэй холбоотой харилцаанд үйлчилнэ.

3.2.Энэ хууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцаанд үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."гадаад худалдаа" гэж барааг экспортлох, импортлох үйл ажиллагааг;

4.1.2."демпинг" гэж гадаад улсаас импортолж буй барааг экспортлогч улсын дотоодын зах зээл дэх ижил төрлийн барааны хэвийн үнээс доогуур үнээр Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдахыг;

4.1.3."импорт" гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт бараа оруулахыг;

4.1.4."квот" гэж эрх бүхий байгууллагаас Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс экспортлох, импортлох барааны тоо, хэмжээ, нийт үнийн дүнг хязгаарлах арга хэмжээг;

4.1.5."тарифын квот" гэж тогтоосон квотын дотор импортын бараанд хөнгөлөлттэй тариф, квотоос давсан хэмжээнд илүү өндөр тариф ногдуулахыг;

4.1.6."татаас" гэж гадаад улсын засгийн газар, төрийн байгууллагаас тодорхой этгээд, салбар, бараанд шууд болон шууд бусаар олгосон санхүү, татварын хөнгөлөлт, үнийн дэмжлэг болон түүнтэй адилтгах бусад дэмжлэгийг;

4.1.7."экспорт" гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс бараа гаргахыг;

4.2.Энэ хуулийн 4.1-д зааснаас бусад нэр томъёог Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу ойлгоно.

5 дугаар зүйл.Худалдааны зохицуулалтын зарчим

5.1.Худалдааны зохицуулалтад дараах зарчмыг баримтална:

5.1.1.дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжих, хамгаалах;

5.1.2.Монгол Улсын олон улсын гэрээ, хуульд зааснаас бусад тохиолдолд үл ялгаварлах;

5.1.3.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хараат бус байх;

5.1.4.ил тод, үр ашигтай байдлыг хангах;

5.1.5.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад худалдааны бараанд үндэсний нэн тааламжтай болон үндэсний нөхцөлийг олгох;

5.1.6.Энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, захиргааны шийдвэрээр худалдааг хориглох, хязгаарлах арга хэмжээ нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРӨӨС ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

6 дугаар зүйл.Худалдааг зохицуулах нийтлэг журам

6.1.Хууль, олон улсын гэрээгээр хориглосон, хязгаарласнаас бусад тохиолдолд бараа экспортлох, импортлох үйл ажиллагааг хүн, хуулийн этгээд чөлөөтэй эрхэлж болно.

6.2.Худалдааг зохицуулах арга хэмжээг Монгол Улсын олон улсын гэрээ, хуульд нийцүүлэн судалгаа, баримтад үндэслэн, үр дагаврыг тооцож хэрэгжүүлнэ.

6.3.Худалдааг зохицуулах арга хэмжээ авсан талаарх шийдвэрийг тухайн шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага олон нийтэд мэдээлж ажиллана.

7 дугаар зүйл.Тарифын арга хэмжээ

7.1.Барааг импортлох, экспортлоход гаалийн татварын хувь, хэмжээг тогтоох, өөрчлөх замаар тарифын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.2.Тарифын арга хэмжээг Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль болон Гаалийн хууль тогтоомжид нийцүүлэн хэрэглэнэ.

7.3.Засгийн газар худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал, Худалдааны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн гаалийн тарифын хувь, хэмжээг дараах тохиолдолд өөрчлөн тогтоож болно:

7.3.1.үндэсний аюулгүй байдлыг хамгаалах;

7.3.2.дайн, зэвсэгт мөргөлдөөн, гамшгаас шалтгаалсан хангамжийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх;

7.3.3.стратегийн барааны хангамж, нийлүүлэлт, тээврийн аюулгүй байдлыг хангах;

7.3.4.дотоодын үйлдвэрлэл, шударга өрсөлдөөн, ажлын байрыг хамгаалах, дэмжих;

7.3.5.демпингийн үнээр барааг импортолж байгаа нь хянан магадлах ажиллагаагаар тогтоогдсон;

7.3.6.татаастай бараа импортолж байгаа нь хянан магадлах ажиллагаагаар тогтоогдсон;

7.3.7.төлбөрийн тэнцлийг сайжруулах;

7.3.8.хуульд заасан бусад.

8 дугаар зүйл.Экспорт, импортыг хориглох, хязгаарлах

8.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар экспортлох, импортлохыг хориглох, хязгаарлах барааны жагсаалтыг Худалдааны зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн дараах үндэслэлээр барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу батална:

8.1.1.үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор экспорт, импортыг;

8.1.2.хүн, амьтан, ургамлын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор экспорт, импортыг;

8.1.3.түүх, археологи, соёлын өвийг хамгаалах зорилгоор экспортыг;

8.1.4.дотоодын үйлдвэрлэл, шударга өрсөлдөөн, ажлын байрыг хамгаалах, дэмжих зорилгоор экспорт, импортыг;

8.1.5.төлбөрийн тэнцлийг сайжруулах зорилгоор импортыг;

8.1.6.стратегийн барааны хангамж, нийлүүлэлт, тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор экспортыг;

8.1.7.хуульд заасан бусад.

9 дүгээр зүйл.Экспорт, импортын квот тогтоох

9.1.Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Худалдааны зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн тухайн жилд экспорт, импортын квот тогтоох барааны нэр, төрөл, тоо хэмжээний саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

9.2.Засгийн газар энэ хуулийн 8.1-д заасан үндэслэлээр экспорт, импортын квот тогтоох барааны жагсаалтыг барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу батална.

9.3.Засгийн газар экспорт, импортын квот тогтоох аргачлалыг батална.

9.4.Экспорт, импортын квотыг энэ хуулийн 9.3-т заасан аргачлалыг баримтлан дараах аргыг сонгон олгоно:

9.4.1.хүсэлт гаргасан дараалал;

9.4.2.дуудлага худалдаа;

9.4.3.сонгон шалгаруулалт;

9.4.4.хувь тэнцүүлэх.

9.5.Экспорт, импортын квотыг тогтоосон хугацаанд ашиглаагүй бол ашиглагдаагүй квотыг энэ хуулийн энэ хуулийн 9.4-т заасан аргын дагуу дахин хуваарилна.

9.6.Экспорт, импортын квотыг бусдад шилжүүлэх, худалдах, барьцаалахыг хориглоно.

10 дугаар зүйл.Тарифын квот тогтоох

10.1.Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Худалдааны зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн тухайн жилд тарифын квот тогтоох барааны нэр, төрөл, тоо хэмжээний саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

10.2.Засгийн газар энэ хуулийн 8.1-д заасан үндэслэлээр тарифын квот тогтоох барааны жагсаалтыг барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу батална.

10.3.Засгийн газар тарифын квот тогтоох аргачлалыг батална.

10.4.Импортын тарифын квотыг экспортын бараа үйлдвэрлэх, боловсруулахад ашигладаг бараанд тогтоохгүй.

10.5.Тарифын квотыг бусдад шилжүүлэх, худалдах, барьцаалахыг хориглоно.

11 дүгээр зүйл.Экспорт, импортыг түр зогсоох

11.1.Засгийн газар худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, Худалдааны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 8.1-д заасан үндэслэлээр экспорт, импортыг 3 хүртэл сарын хугацаагаар түр зогсоох барааны нэр, төрлийг тогтоож болно.

11.2.Экспорт, импортыг түр зогсоох арга хэмжээг тогтоосон шийдвэрийн хүчинтэй хугацаа дууссан, эсхүл тухайн бараа энэ хуулийн 11.1-д заасан барааны нэр, төрөлд хамаарахгүй болсон тохиолдолд уг арга хэмжээг хүчингүй болгоно.

12 дугаар зүйл.Тарифын болон тарифын бус арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх

12.1.Засгийн газар худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, Худалдааны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн дараах бараанд тарифын болон тарифын бус арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шийдвэр гаргана:

12.1.1.дайн, зэвсэгт мөргөлдөөн явагдаж байгаа, эсхүл оролцож байгаа, эсхүл зэвсэгт мөргөлдөөн үүсэх өндөр эрсдэлтэй улс, бүс нутгаас гаралтай бөгөөд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх бараа;

12.1.2.тухайн бараатай холбоотой осол, доголдол, техникийн алдаа гарсныг эрх бүхий байгууллагаас албан ёсоор мэдээлсэн, эсхүл тухайн бараа нь хэрэглэгчийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулах эрсдэлтэй нь нотлогдсон улс, бүс нутгаас гаралтай бараа;

12.1.3.байгаль орчин, экологи, биологийн олон янз байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байгааг эрх бүхий байгууллагаас албан ёсоор мэдээлсэн, эсхүл шинжлэх ухааны үндэслэлээр нотлогдсон улс, бүс нутгаас гаралтай бараа;

12.1.4.төлбөрийн тэнцлийн ноцтой алдагдал үүссэн тохиолдолд;

12.1.5.хуульд заасан бусад.

12.2.Засгийн газар энэ хуулийн 12.1-д заасан нөхцөл арилсан тохиолдолд нэн яаралтай арга хэмжээг хүчингүй болгоно.

13 дугаар зүйл.Хариу арга хэмжээ

13.1.Засгийн газар дараах үндэслэлээр худалдаанд хязгаарлалт тогтоох хариу арга хэмжээ авч болно:

13.1.1.тухайн улс Монгол Улстай байгуулсан олон улсын гэрээний үүргээ биелүүлээгүй;

13.1.2.тухайн улс Монгол Улс, эсхүл Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн, эсхүл олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээний дагуу хамгаалаагүй, зах зээлд нэвтрэх боломжийг үндэслэлгүйгээр хязгаарласан, ялгаварлан гадуурхсан;

13.1.3.гадаад улсын иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйл ажиллагаанаас Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учирсан, эсхүл учруулах бодит эрсдэл үүссэн тохиолдолд тухайн улс уг үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах талаар олон улсын гэрээ, хамтын ажиллагааны хүрээнд шаардлагатай арга хэмжээг аваагүй.

13.2.Худалдааны зөвлөл энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдлын талаар холбогдох мэдээллийг цуглуулж, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

13.3.Худалдааны зөвлөл хариу арга хэмжээ авах шаардлагатай гэж дүгнэлт гаргасан тохиолдолд худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн, холбогдох санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

13.4.Хариу арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох тухай шийдвэрийг Засгийн газар гаргана.

14 дүгээр зүйл. Худалдааны зөвлөл

14.1.Худалдааны зөвлөл худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

14.2.Худалдааны зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд байна.

14.3.Худалдааны зөвлөл худалдааны нэгдсэн бодлого, хөрөнгө оруулалт, гааль, татвар, гадаад харилцаа, хөдөө, аж ахуй, аж үйлдвэр, эрдэс баялагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон эрдэм шинжилгээ, судалгаа, салбарын мэргэжлийн нэгдсэн холбоодын төлөөллөөс бүрдсэн 11 гишүүнтэй байна.

14.5.Худалдааны зөвлөл ажлын албатай байх бөгөөд Ажлын алба нь худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байна.

14.6.Худалдааны зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

14.7.Худалдааны зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.7.1.гаалийн татвар, тарифын зохистой тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг оновчтой тогтоох асуудлаар санал дүгнэлт гаргах;

14.7.2.худалдааг хөнгөвчлөх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах, хууль тогтоомжийн төсөлтэй урьдчилан танилцах, батлагдахаас өмнө саналаа хүргүүлэх;

14.7.3.Монгол Улсаас бусад улс, бүс нутагтай байгуулах худалдааны хэлэлцээрт санал дүгнэлт өгөх;

14.7.4.худалдааны үйл ажиллагааг зохицуулах талаар байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлэх;

14.7.5.транзит, коридорын төвлөрлийн эрсдэлийг жил бүр үнэлэх.

14.8.Худалдааны зөвлөл худалдааны арга хэмжээний талаар дараах шалгуур үзүүлэлтийн дагуу хоёр жил тутамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлтийг худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ:

14.8.1.Монгол Улсын эдийн засаг, төсвийн орлогод үзүүлэх нөлөө;

14.8.2.дотоодын үйлдвэрлэл, нөөцөд үзүүлэх нөлөө;

14.8.3.үнэ, инфляц, өрхийн амьжиргаа, нийлүүлэлтийн сүлжээ, өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөө;

14.8.4.гаалийн бүрдүүлэлтийн хугацаа, зардалд үзүүлэх нөлөө;

14.8.5.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтад нийцэж байгаа байдал.

14.8.6.хуульд заасан бусад.

14.9.Энэ хуулийн 14.8-д заасан хяналт шинжилгээ, үнэлгээг хийхдээ хөндлөнгийн шинжээч, мэргэжлийн нэгдсэн холбооны оролцоог хангана.

14.10.Энэ хуулийн 14.8-д заасан дүгнэлтэд авч хэрэгжүүлж байгаа тарифын арга хэмжээний үр нөлөө, шаардлагатай тохиолдолд тарифыг өөрчлөх санал, үндэслэл, гарах үр дүнг тусгана.

14.11.Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Худалдааны зөвлөлөөс ирүүлсэн дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУДАЛДААГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

15 дугаар зүйл.Худалдааг хамгаалах арга хэмжээ

15.1.Худалдааг хамгаалах арга хэмжээ нь демпингийн эсрэг арга хэмжээ, татаас болон саармагжуулах арга хэмжээ, хамгаалалтын арга хэмжээнээс бүрдэнэ.

15.2.Демпингийн эсрэг арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

15.2.1.демпингийн эсрэг татвар ногдуулах;

15.2.2.демпингийн эсрэг үнийн амлалт авах.

15.3.Татаас болон саармагжуулах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

15.3.1.саармагжуулах татвар ногдуулах;

15.3.2.экспортлогч улсын Засгийн газраас татаасыг арилгах буюу бууруулах амлалт авах;

15.3.3.экспортлогчийн үнийн амлалт авах.

15.4.Хамгаалалтын арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

15.4.1.хамгаалалтын татвар тогтоох;

15.4.2.импортын квот тогтоох;

15.4.3.тарифын квот тогтоох;

15.4.3.импортын тусгай зөвшөөрлийн горим хэрэгжүүлэх.

15.5.Энэ хуулийн 15.2, 15.3, 15.4-т заасан худалдааг хамгаалах арга хэмжээг дараах тохиолдолд хэрэгжүүлнэ:

15.5.1.демпингийн улмаас ижил төрлийн барааны дотоодын үйлдвэрлэлд хохирол учирсан, эсхүл учрах аюул бий болсон;

15.5.2.татаастай импортын улмаас ижил төрлийн барааны дотоодын үйлдвэрлэлд хохирол учирсан, эсхүл учрах аюул бий болсон;

15.5.3.импортын огцом өсөлтөөс ижил, эсхүл шууд өрсөлдөх бараа үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учирсан, эсхүл учрах аюул бий болсон.

16 дугаар зүйл.Хянан магадлах ажиллагаа

16.1.Худалдааны зөвлөл энэ хуулийн 15.5-д заасан нөхцөл үүссэн эсэхийг тогтоох зорилгоор хянан магадлах ажиллагааг хэрэгжүүлнэ.

16.2.Худалдааны зөвлөл хянан магадлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл ижил, шууд өрсөлдөх барааг үйлдвэрлэгч тухайн хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр хийнэ. Хүн, хуулийн этгээдийн хүсэлт нь бичгээр, эсхүл цахим хэлбэртэй байж болно.

16.3.Худалдааны зөвлөл хүн, хуулийн этгээдийн хянан магадлах ажиллагаа хийлгэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор хянан магадлах ажиллагааг эхлүүлэх эсэх тухай шийдвэр гаргана.

16.4.Хянан магадлах ажиллагааг эхлүүлэх тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 1 жилийн дотор хянан магадлах ажиллагааг дуусгана. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

16.5.Хүн, хуулийн этгээдийн хянан магадлах ажиллагаа хийлгэх хүсэлт нь Монгол Улсын олон улсын гэрээнд заасан шаардлага, шалгуурыг хангаагүй, эсхүл хянан магадлах ажиллагаа эхлүүлэхэд шаардагдах хангалттай нотлох баримт ирүүлээгүй бол Худалдааны зөвлөл хянан магадлах ажиллагааг эхлүүлэхээс татгалзаж, энэ талаар хүн, хуулийн этгээдэд даруй мэдэгдэнэ.

16.6.Энэ хуулийн 15.5-д заасан нөхцөл үүссэн эсэхийг тодорхойлох, урьдчилсан байдлаар тогтоох аргачлалыг Засгийн газар батална.

16.7.Энэ хуулийн 16.6-д заасан аргачлалын дагуу хянан магадлах ажиллагаа хийх явцад энэ хуулийн 15.5-д заасан нөхцөл урьдчилсан байдлаар тогтоогдсон тохиолдолд энэ хуулийн 15.2.1, 15.3.1, 15.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж болно.

16.8.Хянан магадлах ажиллагаагаар энэ хуулийн 15.5-д заасан нөхцөл үүсээгүй болох нь эцэслэн тогтоогдсон тохиолдолд энэ хуулийн 16.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнөх байдлыг сэргээнэ.

16.9.Худалдааны зөвлөл хянан магадлах ажиллагааны явцад холбогдох хүн, хуулийн этгээдээс мэдээлэл, тайлбар гаргуулан авах эрхтэй. Хүн, хуулийн этгээд хянан магадлах ажиллагааны явцад үнэн зөв мэдээлэл ирүүлэх үүрэгтэй.

16.10.Хянан магадлах ажиллагааны явцад ирүүлсэн худалдаа, үйлдвэрлэл, санхүү, үнэ болон бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бусад нууц мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно.

16.11.Худалдааны зөвлөл хянан магадлах ажиллагаанд ашигласан мэдээллийг хүсэлт шийдвэрлэх, дүгнэлт, зөвлөмж гаргахад ашиглана.

16.12.Худалдааны зөвлөл шаардлагатай гэж үзвэл хянан магадлах ажиллагааны явцад нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж болно.

16.13.Худалдааны зөвлөл хянан магадлах ажиллагааг эхлүүлэхээр шийдвэрлэсэн бол олон нийтэд мэдээлж, Дэлхийн Худалдааны Байгууллагын холбогдох хороонд мэдэгдлийг хүргүүлнэ.

16.14.Хянан магадлах ажиллагаагаар энэ хуулийн 15.5-д заасан нөхцөл үүссэн нь тогтоогдсон тохиолдолд Худалдааны зөвлөл худалдааг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх дүгнэлт, зөвлөмж гаргана.

16.15.Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Худалдааны зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг худалдааг хамгаалах арга хэмжээг сонгон хэрэгжүүлэх саналын хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

17 дугаар зүйл.Худалдааг хамгаалах арга хэмжээний хэрэгжилт, хяналт

17.1.Худалдааны зөвлөл худалдааг хамгаалах арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөг үнэлж, дүгнэлт гаргана.

17.2.Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 17.1-д заасан үнэлгээ, дүгнэлтийг худалдааг хамгаалах арга хэмжээг өөрчлөх, эсхүл цуцлах тухай саналын хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ДЭМЖИХ,
ЦАХИМЖУУЛАЛТ**

18 дугаар зүйл.Худалдааг хөнгөвчлөх

18.1.Худалдааны зөвлөл дараах худалдааны үйл ажиллагаанд жил бүр шинжилгээ, үнэлгээ хийж шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй, худалдаанд үндэслэлгүй саад учруулсан зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх, үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, хялбаршуулах талаар санал дүгнэлт гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ:

18.1.1.худалдааны үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын үр дагавар;

18.1.2.хил, гаалиар нэвтрүүлэх болон бусад худалдааны үйл ажиллагаанд шаардах мэдээлэл, баримт бичгийн тоо, зөвшөөрөл олголт, төлбөр, хураамж, зарцуулж байгаа хугацаа, зардал, хяналт шалгалтын давтамж, хэрэглэгчийн үнэлгээ;

18.1.3.боомтын үйл ажиллагааны болон тээврийн тасалдал, эсхүл төвлөрснөөс хүн, хуулийн этгээдэд үүсэх эрсдэл, нэмэлт зардал.

18.2.Хүн, хуулийн этгээд худалдааны үйл ажиллагаанд тулгарч байгаа саад, хүндрэлийг арилгуулах, худалдааны үйл ажиллагааг хялбаршуулах талаар Худалдааны зөвлөл, холбогдох эрх бүхий байгууллагад гомдол, хүсэлт гаргаж болно. Худалдааны зөвлөл гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд хянан үзэж, шаардлагатай бол эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж, шийдвэрлэлтийн явц, үр дүнг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

18.3.Худалдааны зөвлөл энэ хуулийн 18.2-т заасан хүсэлтээр илэрсэн саад, хүндрэл, түүнийг шийдвэрлэсэн байдлын талаар нэгдсэн бүртгэл хөтөлж, дүнг жил бүр олон нийтэд мэдээлж, Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

18.4.Худалдааны зөвлөл худалдааны үйл ажиллагааг хөнгөвчлөх талаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

19 дүгээр зүйл.Худалдааг дэмжих

19.1.Төр худалдааны үйл ажиллагаанд дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ:

19.1.1.Монгол Улсын болон олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад улс, бүс нутгийн зах зээлийг судалж, мэдээллийг ил тод болгох;

19.1.2.гадаад улсын зах зээлд нэвтрэх, бараа экспортлох талаар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

19.1.3.барааны хомсдолд нөлөөлөх хүчин зүйл, эрсдэл, тэдгээрийн таамаглалын талаар судалгаа хийж, үр дүнг олон нийтэд мэдээллэх;

19.1.4.гадаад худалдаа эрхлэгч, тээвэрлэгч, зуучлагч, голлох салбарын үйлдвэрлэгч хуулийн этгээдэд хөрөнгө оруулалт хийх, хувьцааг худалдан авах;

19.1.5.голлох бараа, түүхий эдийн үний өсөлт, тогтвортой байдлыг хангах зорилгоор хөрөнгийн болон барааны биржийн арилжаанд оролцох, хөрөнгө оруулалт хийх, хөнгөлөлттэй зээл олгох;

19.1.6.далайн тээвэр, боомт, ачиж, буулгах терминал, төмөр замын тээвэр, ложистикийн улс дамнасан сүлжээг үүсгэх, тээврийн дэд бүтцийг сайжруулах;

19.1.7.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрээр тээврийн хэрэгсэл чөлөөтэй дамжин өнгөрөх нөхцөлийг бүрдүүлэх;

19.1.8.экспортын бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд сурталчлах, олон улсын үзэсгэлэн, яармагт оролцоход дэмжлэг үзүүлэх;

19.1.9.дэвшилтэт техник, технологи нутагшуулах;

19.1.10.үндэсний стандарт боловсруулах, олон улсын стандартад нийцүүлэх, бүртгүүлэх;

19.1.11.худалдааны санхүүжилт, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн механизм, баталгаа, даатгал, факторинг, форфейтинг болон бусад санхүүгийн хэрэгслийг ашиглах, хөгжүүлэх, зохицуулах, дэмжих;

19.1.12.экспорт, импортын хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хүүгийн татаас үзүүлэх;

19.1.13.экспортын зээлийн батлан даалт, даатгалын үйлчилгээ үзүүлэх.

19.2.энэ хуулийн 19.1-д заасан санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын холбогдох тусгай сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

20 дугаар зүйл.Гадаад худалдааны цахим нэг цонх

20.1.Хүн, хуулийн этгээдээс импорт, экспорт, дамжин өнгөрөхтэй холбоотой баримт бичиг, мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, эрх бүхий байгууллага холбогдох шийдвэрийг гаргаж хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем (цаашид “систем” гэх)-ээр дамжуулан үзүүлнэ.

20.2.Төрийн эрх бүхий байгууллага нь өөрт байгаа, эсхүл энэ хуулийн 20.1-д заасан системээр дамжуулан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс давхардуулан шаардахгүй бөгөөд нэг мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлнэ.

20.3.Системийн мэдээлэл, өгөгдөл нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өгөгдлийн стандарт, шаардлагад нийцсэн байна.

20.4.Системээр гадаад улсын эрх бүхий байгууллагатай бичиг баримт, мэдээлэл, өгөгдлийг холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу цахим хэлбэрээр харилцан солилцоно.

20.5.Гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон цахим баримт бичгийг Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл хуульд заасны дагуу хүлээн зөвшөөрнө.

20.6.Хөрөнгө оруулалт, худалдааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага системийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах бөгөөд бусад улсын гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх системтэй холбох, мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлнэ.

20.7.Системд бүртгэгдсэн худалдааны үйл ажиллагаатай холбоотой байгууллагын болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулахыг хориглоно.

21 дүгээр зүйл.Мэдээллийн сан

21.1.Худалдааг дэмжих, хамгаалах, зохицуулах, хөнгөвчлөх, худалдааны эрсдэлийг удирдах, судалгаа, дүн шинжилгээ хийх худалдааны мэдээллийн сантай байна. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

21.2.Мэдээллийн санг бүрдүүлэх, санд оруулах мэдээлэл, мэдээлэл гаргах эрх бүхий байгууллагын жагсаалтыг худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

21.3.Эрх бүхий байгууллага нь мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр шуурхай гаргаж цахим хэлбэрээр хүргүүлнэ.

21.4.Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.1-д заасан мэдээллийн сангийн мэдээллийг нээлттэй өгөгдөл болгож ашиглах боломжийг бүрдүүлнэ.

22 дугаар зүйл.Гарал үүслийн гэрчилгээ

22.1.Барааны гарал үүслийн гэрчилгээ олгох журмыг худалдааны нэгдсэн бодлогын болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22.2.Тодорхой барааны гарал үүслийн гэрчилгээ олгох чиг үүргийг холбогдох мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад шилжүүлж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

23 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

23.1.Засгийн газар худалдааг зохицуулах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.экспортын бүтээгдэхүүнийг олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

23.1.2.гадаад худалдаанд эрсдэл бүхий нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрт сэрэмжлүүлэх, сөрөг нөлөөллийг бууруулах,

хохирол багатай даван туулах, сөрөн тэсвэрлэх чадавхийг сайжруулах, бэлэн байдлын төлөвлөгөө батлах;

23.1.3.Монгол Улсаас гаралтай бараа гадаад улсын нутаг дэвсгэр дээгүүр болон дамжин өнгөрөх нөхцөл боломж, хорио цээр, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг хөнгөлөх, зардалыг бууруулах, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

23.1.4.Улсын Их Хурлаас тогтоосон хувь хэмжээний хүрээнд гаалийн тарифын хувь хэмжээг тогтоох;

23.1.5.экспортлох, импортлохыг хориглох, хязгаарлах барааны жагсаалтыг батлах;

23.1.6.экспорт, импортын квот тогтоох барааны жагсаалтыг батлах;

23.1.7.тарифын квот тогтоох барааны жагсаалтыг батлах;

23.1.8.стратегийн барааны жагсаалт батлах;

23.1.9.экспорт, импортыг түр зогсоох, хүчингүй болгох;

23.1.10.тарифын болон тарифын бус арга хэмжээг нэн яаралтай хэрэгжүүлэх шийдвэр гаргах, өөрчлөх, хүчингүй болгох;

23.1.11.худалдааны хариу арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох;

23.1.12.худалдааг хамгаалах арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох;

23.1.13.хуульд заасан бусад.

24 дүгээр зүйл.Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

24.1. Худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдааг зохицуулах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

24.1.2.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай худалдааны гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Засгийн газарт танилцуулах;

24.1.3.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулах худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэлэлцээг зохион байгуулах;

24.1.4.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулах худалдааны гэрээ, хэлэлцээрийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах;

24.1.5.худалдааны төлөөлөгчийг томилох;

24.1.6.бусад улстай байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээр, протоколын хэрэгжилтийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр үнэлэх;

24.1.7.хуульд заасан бусад.

25 дугаар зүйл.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

25.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу худалдаатай холбоотой хууль тогтоомж, бодлого, арга хэмжээ болон тэдгээрийн өөрчлөлтийн

талаарх мэдэгдлийг холбогдох олон улсын байгууллагад тогтоосон хугацаа, журмын дагуу хүргүүлэх;

25.1.2.дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан зах зээлийн мэдээлэл цуглуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх.

26 дугаар зүйл.Худалдааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

26.1.Худалдааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага худалдааг зохицуулах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.худалдааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтийг худалдааны нэгдсэн бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

26.1.2.энэ хуульд заасан экспортын дэмжлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

26.1.3.худалдаа эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын үзэсгэлэн, яармаг, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;

26.1.4.худалдааны мэдээллийн санг хариуцах;

26.1.5.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, сурталчлах, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангах.

27 дугаар зүйл.Худалдааны төлөөлөгч

27.1.Хүлээн авагч улсад суугаа худалдааны төлөөлөгчийн тусгай орон тоо бүхий Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар Монгол Улсын гадаад худалдааны хууль, эрх зүйн орчин, эдийн засгийн нөхцөл байдал, экспортыг дэмжих хөтөлбөрийг сурталчлах, гадаад худалдаа эрхлэгчийг холбох, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

28 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль^[7], эсхүл Зөрчлийн тухай хуульд^[8] заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль^[9], Захиргааны ерөнхий хуульд^[10] заасан хариуцлага хүлээлгэнэ.

29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг